

ДОРНЫН СОНГОДОГ
ЗОХИОЛЫН
ЦОМОРЛИГ

ТҮВДИЙН АЛДАРТ ЯРУУ НАЙРАГЧ
ИХ ЕГҮЗЭР (JOGO) МИЛАРАБЫН
НАМТАР

Бидний өгүүлэн буй уг судрын дэлгэрэнгүй нэр нь «Егүзэрийн (jogo) эрхэт баялаг дээд богд Миларабын намтар, хамгийг айлтгагчийн мөрийг үзүүлэгч оршивой» хураангуй нэр нь «Милын намтар»,

Уг зохиол мөргөлийн хэсэг, 12 бүлэгтэй товч хурваас 2 гол хэсэгт хуваагдах үүнд: «Нийт сансар ертөнцийн зохиол», «Дээд болсон амирлангуй, муу гаслангаас гэтэлсний зохиол» болой.

1. Уг удамд мила хэмээхүйн учир шалтгаан эцэг хүмүүн бэр дамжин гарсан уг луга сэлтэст бөгөөс бие мэндэлсний зохиол.

2. Багадаа эцэг бие шингэж (өөд болж) ойрын садан дайсанд боссон бөгөөс гадаад, дотоодын төгс эдлэл бүхэн лүгээ хагацсан бөгөөд зовлонгийн үнэний туйлд хүрсэнийг анхааран авсаны зохиол.

3. Эжийн зарлиг шаардлагаас илт явдлын үйлсийг бүтээснээс дайсан нигуудын өрийг төнхөсний зохиол луга 3 бүлгээс энд I, II бүлгийг бүрэн орчуулгаар хэвлэн нийтэлж уншигч түмэндээ толилуулаюу.

Өгүүлэгч миний бие энэ ялдамд нэгэн зүйлийг зориуд өгүүлэхэд энэ сонин гайхамшигт намтар зохиолыг бидний эцэг өвгөд маань туйлаас шимтэн уншаад тэрээр зохист аялгууны аман орчуулгыг нарийвчлан боловсруулж ирсэн сайхан уламжлал байсан тухай Академич бурхан болооч Ринчен багш надад энэ номын судрын аман орчуулгыг хуучуул, номтой лам нарын аман орчуулгыг сонсголонгоор тогтоон авах яавч хэрэгтэй гэж бие, хэл, сэтгэлийн алжаалаа умартан байж уг зохиолын чухал болох судлах арга замыг нэгд нэгэнгүй сургамжлан хэлээд, мөн сэтгэлчлэн өөрийн гараараа төлөвлөгөө гарган хайрласны нь гар бичмэл эхээр нь хавсарган энд нийтлэвэй.

Бүлэг 1. Хар үйлийг (нүгэл) зохиосон ёс, уг дамжлага төрөл олсоны ёс

Ийн хэмээн би бэр сонссон цаг нэгнээ;

Егүзэрийн эрхэт баялаг Богд Милшадавдорж хэмээн алдар чухамтай алдаршсан Хэрүга (Невајга) их тэр, Нянам нэрт орон аглаг агуйд бясалгалаар суун ахуй цагт. Дээд төрөлхтөн Райчүндорждагва, Райвашива-Од, Анзон-райва, Сэван-райва, Чэр-Райва, Врэгомрайва, Лонгом-Райва, Райвасанжаажав, Шингорайва, Дамбажагпүва, Дон башагжагүн тэргүүтэн сэтгэлийн хүвгүүд (шавь) егүзэр, газар дээрх бодсаддва (бодсэтгэлт хийгээд Лэгсийбум, Шиндормо бөгөөд хувь төгс (сайн хувьтан), өглөгийн эзэд эр, эм, урт наст 5 охин тэнгэр тэргүүтэн цуглаж болой. Мөн солонгон биет огторгуйгаар явагч дагнис, бас бус үндэс чухамтай ариун тэнгэр, хүмүүн, егүзэр, (бясалгачин) эр, эм чуулган луга сэлтэстийн гол дунд их хөлгөний номын хүрдийг эргүүлэх (номнох) бөгөөд сууж болой.

Тэр цагт төрөлхтөн Райчүн байшин өөрийн бясалгалын агуйд сэтгэлийн дээдэд залран байхын шөнө туршийн нэгэн зүүдэнд Үржин ()-гийн орон тива мөн хэмээхүй орон газар сэтгэлд зохист бөгөөд бясалгал тэгш баясгалантай. Гэр байшингийн уг хийгээд газар дэлхий их эрдэнэ олон зүйлээс бүтсэн, орд харш их нэгний дотор хүрсэн тул орд харш түүний хүмүүн бүхэн торгон дээл өмссөн, яс хийгээд эрдэнийн чимгээр хээлсэн байв. Эндэх хүмүүн агааль ааш сайн бөгөөд харваас гуа үзэсгэлэнт ямагт, тэд бүхэн надад үгийг үл

өгүүлэхүй баясгалангийн мөшгөлт лүгээ төгссөн нүдээ цааш ирмэн, нааш ирмэн, ирмэн харж байваа. Тэдний дотроос урьд Балбад уул заж байсан лам (багш) Дипүвийн шавь Бхаримаа, тэр улаан торгон дээл нэгийг өмсөөд голлохын (хатны) ёсонд сууж байсан тул, ач минь ирэв үү? ирсэн чинь сайн болжуу.

Ач минь ирсэн чинь сайн болжуу, хэмээн өгүүлээд их эрдэнийн гэр байшин хүслүүн тавилга барагдахыг үл мэдэхүй дүүрсэн нэгний дотор хөтөлснөөс хүрч очвол зочны ёсноо идээ ундаа, эргэл хүндлэл сайн бөгөөд дутаггүй ханан цэнгүүлж болой.

Эдүгэ Үржингийн оронд бурхан Мижодва (хүмүүний явдалт) ном зарлиглаж байгаа учир ач минь өөрөө ч ном айлтгаваас, би соёрхолыг айлтгаад ирье хэмээхүйд Райгүнва машид сонсохыг хүссэнээс сайн болой хэмээсэн, тэнгэвэл явъя гээд эм лүгээ эвсэлдэхүй бөгөөд хүрвээс, хот балгас түүний голд их эрдэнийн ширээн суудал өндөр уужмын дээр, ялж төгс нөгчсөн хүмүүний (Жумдандай Мижодва) явдалд бурхан тэр урьд сэтгэлээр бясалгадгаас ч нэн ялгаамжаатай, хэтэрхий нэгэн нөхөр далай мэтийн голд номыг номлохыг үзсэнээр баясгалан, амгалан дуршлаар согтуурах бөгөөд муужирч одох мэт нэгэнг олов.

Түүнээс Бхаримаа өгүүлрүүн:

—Ач минь өөрөө энд түр нэг азнагтун!

—Би бурханд соёрхолыг айлтгаад ирье хэмээн одсоноос, соёрхолыг олжүү.

—Бас эм хөтөлснөөс бурханы гэгээний дэргэд хүрч мөргөл эрээд, адистэдийг айлтгасанаас мэлмийн өмнө ном сонсох бөгөөд суусан тул, Бурханы гэгээнээ мөшгөлзөх лүгээ сэлтэстийн байдлаас өчүүхэн нэгэн намайг мэлмийгээрээ энэрэн таалж байгаа мөн буюу ихэд дуурьсаж байгаагаас намайг өрөвдөх бөгөөд таалсан мөн хэмээн бодов. Ном зарлигласан хамаг бурхан хийгээд Бодсаддва хамаг бүхний үе, үндэс дамжлага, ясны дараалал, мэндэлсэн зохиол хийгээд сонин явдал (намтар) ямагтыг айлдах бөгөөд байсан тул шар үс хөвхлөн хөдлөхийн сүсэг олжүү. Сүүлд нь маргааш Дилэб, Нароб, Мараб гурвын сонин явдлыг урьд Богд зарлигласнаас дэлгэр бөгөөд гайхамшигтийн эрдэм нигүүдийг зарлиглах байгаа тул шавь нар нөхөр бүхэн дээдэд маш чин бишрэл төрсөн гэдэг.

Номын хойт өдөр, маргааш урьдын номлосон тэр бүхнээс ч эрхэм дээд болсон байгаа Милайрабын сонин явдлын туужийг номлох (өгүүлэх) тул сонсохоор явагтун! гэж зарлиглах бөгөөд байсанд нөхөр, шавь нарын дотроос зарим нь өгүүлрүүн:

— Урьдын тэд нэрээс дээд болгож номлох арга байдаг болов уу? тэр.

— Байваас, гайхамшиг нь нэн хэмжээнээсээ давсан нэгэн байгаа байна хэмээгээд,

— Зарим нь өгүүлрүүн: урдын тэр бүхний эрдэм, гэгээн төрөл олонтойд чуулганыг (буян) хурааж, түйтгэрийг (нүгэл) судалснаас гарсаны үр нь мөн. Милайраб нэгэн нас, нэгэн биеэр эрдмийг урьдын тэд бүхнээс дутахгүйг олсон нэгэн байгаа байна хэмээн, бас урьдын нэг нь өгүүлрүүн:

—Болмойжин, тэр мэтийн ном гайхамшигт ихэд байгаагаас амьтны тусын тулд эс айлтгаваас өвөр бид шавь нарт зохисгвй бөгөөд гурван үүдэн (бие, хэл сэтгэл) хичээл хийгээд самбааг үүсгэж амьтны тусын тулд айлтгах яавч зохистой болой хэмээн:

— Бас зарим нэг нь өгүүлрүүн:

— Милайраб тэр одоо хаана заларч байгаа хэмээхэд:

— Нэгэн нь өгүүллүүн: Илт баясгалант (онга) орон буюу доод бус орон (огмин) алин нэгэнд заларч байгаа болов уу? хэмээн өгүүлэхэд:

— Райчүнвийн сэтгэлд Богд хаана оршиж байгаа бол хэмээхэд: — Тэр төвд л оршиж байгаа байх хэмээжүү болой.

Алин мэд болох нь тэр бүхний өгүүлэх ёс тэр, надад санаа угтуулгыг өгч байгаа тул Богдын сонин явдал туужийг амьтны тусын тулд яахнайч айлтгах хэрэгтэй хэмээхийн цагт,

— Бхаримаа тэр Райчүнвагийн гараас барих бөгөөд базлан, базлан, түлхэн түлхсээр өгүүллүүн:

— Ач минь ухаарч байна уу?

— Ач минь ухаарч байна уу? хэмээхүйн байдлаас, Райчүнва зүүднээс сая сэрэхэд үүр цайх шахамдаж байсан гэдэг.

— Урьдаас Бхаримаа ухаан тунгалаг бөгөөд буяны найрлагат эдлэг ихтэй болсоны байдлаас зүүдний сүүлээр сэтгэл цацарснаас Үржингийн (и-г) оронд чуулганы гол дунд Бурхан хүмүүний явдалт (Мижодва) ном номлож байгаа нь гайхамшиг ихтэй мөн амой. Тэр бэр лам Богд лугаа учирдаг энэ алинаас санав чиг гайхамшиг ихтэй. Бурхан хүмүүний явдалтаас номыг сонсох нь богдын (Милайраб) зарлигийн ач мөн.

— Тэд нэрийг Богд илт баясгалантын (онга) орон буюу **Доод бусын** (огмин) орон алинд заларч буй хэмээн асуухад:

— Райчүнва би богд Төвд л оршиж байгаа хэмээн, Багшид басамжлалын үүднээс адил нөхрийг үйлдэгч өөдгүй чиний өөрийн үзэл мөн. амой. Ер богд бурхан мөний тул бие, хэл, сэтгэлийн зохиолыг санаж сэтгэшгүй.

— Ялангуяа Богд тэр орон алинд заларч байгаа хэмээхэд:

— Илт баясгалан орон (онга) буюу Доод бус оронд (огмин) заларч байгаад сэтгэл итгэмжлэхгүй гутамшгийн буруу үзэлтэн чи өөрөө мөн хэмээн Райчүнва өөртөө зэмлэл олонтаа өгүүлсний сүүлд зүүдэнд ном номоочин хийгээд сонсоочин Бхарими тэд бүхний дохио надад намайг амьтны тусын тулд Богдын сонин явлыг айлтгахын дохионд байгаа тул яах болнойч айлтгах хэрэгтэйг таалруун:

— Багшид сүсэг бишрэл ер бус нэг төрснөөс соёрхолыг зүрхний тольт ясны голоос тавьжуу амой.

Райчүнва түр нэг сэтгэлийн дээдэд оршсон тул бас зүүд хийгээд гэрэл тодорхой нийлэлдэх болой.

Үржингийн орны чимэг хийгээд авир ёстын үзэсгэлэнт өчүүхэн охид цагаан, хөх, шар, улаан ногоон тав Райчүнвагийн өмнө бөтгөөрөлдөж нааш, цааш жигдэрч байсны нэг нь өгүүллүүн:

— Маргааш Милайрабын сонин явдлыг зарлиглах байгаа тул сонсохоор явья хэмээхэд,

— Бас нэг нь өгүүллүүн: — Айлтгаачин нь хэн буй хэмээн,

— Зарим нь өгүүллүүн:

Сэтгэлийн хөвгүүд (шавь) их гайхамшигтай айлтгах бөгөөд зохистой хэмээх цагт, бүхэн Райчүнваад нүдээ мөшгөлзөн ирмэн, ирмэн байсан амой.

Зарим нь өгүүллүүн: Гайхамшигтын номыг сонсоход бүхэн таалах тул өвөр бид бүхэн соёрхолыг тавих зохист хэмээв. Өвөр бид шашинг дэлгэрүүлэх хийгээд тэтгэх цаг нь тулгарсан мөн хэмээснээс солонго завхрах мэт оджүү болой. Тэр Райчүнваа бас гэрэл тодорхой дээшилсэн (боссон) тул огторгуйд нар сая ургаж байсан гэдэг. Райчүнваагийн сэтгэлд урт наст 5 охин тэнгэрийн дохио тэр байсныг сэтгэн, сэт-

гэлийн дээд сүүлийг олохын байдалд зоогийг бэлтгэж үйлдэх бөгөөс ханан цангээд багшийн дэргэд хүрвээс, нөхөр хуварга, шавь нар, өглөгийн эзэн лүгээ сэлтэст ч багшийн (Милайраб) дэргэд жигдэрч бүрдсэн байсан гэдэг.

— Райчүнваа Богд Милайрабад мөргөлийг эрээд:

— Амгаланг айлтгаснаас, Богдын дэргэд өвдөг цөгцийж, алгаа хавсрах бөгөөд ийн хэмээн соёрхолыг тавьсан болой.

- Багш! Богд (гэтэлгэгч тойн) их эрдэнэ урьд өнгөрсөн Бурханы зохиол «арван хоёр аймаг»-т эргүүлэн, сонин явдал санаж сэтгэшгүй. Амьтны тусын тулд зарлигласан байгаа нь ертөнцөд Бурханы шашин дэлгэрэх мөн бөгөөд Дилэб, Нароб, Мараб тэргүүтэн хийгээд багш бүтээлийг олж, урьдын тэд бүхэн ч өөр, өөрийн сонин явдлыг зарлигласан байгаа амой. Одоо хувь төгстөн (сайн хувьтан) шавь нар боловсруулан гэтэлгэхийн мөрд байгуулан чадсан мөн болбоосуу.

— Одоо Богд их эрдэнэ та, өвөр бид шавь нар, төрөлхтөн хийгээд ирээдүйн хувь төгстөн шавь нар даган дэмжих бөгөөд бас бус бэртэг төрөлхтөн даягааранг боловсруулан гэтэлгэхүйд суралцан үйлдэх арганд сэтгэл их нигүүлсэн зохио!

— Богд их эрдэнэ та өөрийн яс хийгээд овог гарал лугаа сэлтэст юун болой. Сонин явдал, зохиолоос зарлиглан соёрх! хэмээн залбирал тавиваасуу:

— Богд их, мөшгөлзөх лүгээ сэлтэст бөгөөс

— Райчүнваа өөрөө миний авир ёсыг чи ихэд хэрэглэнэ үү?

— Асууваас, хариулахыг хичээж үйлдэнэ болой.

— Миний яс Чумбо

— Овог Жосрай

— Би өөрөө Миларайба

— Анханд нүгэл ч үйлдсэн (үйл харыг ч)

— Завсарт буяныг ч үйлдсэн (үйл цагааныг)

— Одоо нүгэл, буян хоёулан лугаа хагацсан бөгөөд үйлийн суурь шүтээн барагдсан тул ирээдүйд үйлдэх үгүй болсон нэгэн мөн бөгөөд гэрийг дэлгэр номновоосуу.

— Зарим, зарим нь инээх, зарим, зарим нь уйлахын учир шалтгаан олон буй тэр.

—Өгүүлбээсүү? хэрэг нь бага, хөгшин хүмүүнийг ямар чөлөөтэй суухад оруул! хэмээхэд:

— Бас Райчүнваа мөргөл дахин, дахин эрэхүйлүгээ соёрхолыг тавьж, Богд их эрдэнэ ээ!

— Та анханд хатуужил хийгээд санаа шийдэмгий чандад увидас (арга) гүн нарийг бясалган авсан бөгөөд нэгэн сэтгэлийн бүтээлийг онцгойлон зохиосон тул эдүгээ орон, ёс илтэд болгосон болой. Та номыг барагдахын газарт дөхүүлсэн, ирээдүйд хүлэгдэж болохын үйлийг үл зохиох бөгөөд эс амсах бүхнийг зохиолдуу бүтээсэн мөн амой.

— Милайраба өгүүлэх нь:

— Яс Чумбо

— Овог Жоорой

— Над Мила хэмээн нэр өгөх болсон учир шалтгаан хийгээд бие мэндэлсний анханд: Нүгэлийг үйлдсэний ёс, завсарт, буяны үйлийг үйлдсэн ёсыг шүтсэнээс түүнд тааллын утга, санаа сэтгэшгүй нэгэн байгаа мөн тул би тэргүүтэн хамаг амьтан бүхэнд сэтгэл их нигүүлсэнгүйг үүсгэх мөн болой.

— Бие, зарлиг, сэтгэлээр залхууралгүй (хоригшолгүй) оршсонд дэлгэр номнон соёрхоё. Та нар энд цугласан ах дүү Очирын садан сүжиглэн хурсан өглөгийн эзэд ч над залбирлыг тавих нөхрийг зохиож,

айлтга хэмээн соёрхолыг тавьж, мөргөлийг дахин, дахин эрээд түүнд сэтгэлийн хөвгүүд их нигууд ба сүжигтэн, өглөгийн эзэд мөргөлийг дахин олонтой эрснээс төрөлхтөний дээд Райчүнваа залбирал тавин зарлигийг хайрлах бөгөөс номын хүрдийг эргүүлэн соёрх! хэмээн соёрхлыг дахин дахин тавихад:

— Богдын гэгээнээс, (Миларайба) та бүхэн тэр төдийг хэрэгшээн шамдаж дахин асууваас,

— Би нуухын хэрэггүй номлож үйлдэнэ болой.

— Миний яс хийгээд язгуур Чумбо, Төвдийн умар зүгийн Брог нэрт аймгийн их нэгний дотроос:

— Яс Чумбо

— Язгуур хуучин тарничин лам Жосрай нэгний хөвгүүн Егүзэр, Ядам (сэтгэлийн дээд) -ыг даган барьсан хэлний чадал лугаа төгссөн нэгэн, хан гүрэн, орон хүрээ хийгээд шүтэн эргэхүйд Зан орны дээд биед хүрсэн тул умар зүгийн Зүнбажи хэмээхүйд мөргөлөөр хүрсэн. Орон энд ад чөтгөр номхотгох, адистэдийг үйлдэн чадал лугаа төгссөн, тус маш олонтаа гарсанаас номхотгох хийгээд үйлс ихтэй нэрлэгдэж алдар нь Чумбо Жосрайд соёрхсоноос жил хэдүй өнгөрсөн, оронд өв чин ад тэргүүтэн шалтгаан юу гарсан ч урин залагддаг нэгэн болж байсан болой. Тэр нэгэн цагт орон тэнд урьдын Жосрайн зүг ирж үл чадагч ад бусад алинд ч үл чадагдах аюумшиг ихтэй нэгэн гарсан тэр.

Жосрайд маш сүжиггүй хүмүүн айл нэгэнд ад шүглэснээс хорлол гарсан тул лам бусад алинг урин залж, хатуу номхотгол хийгээд адис тэд үйлдэвч ад тэр инээн товхоорон наадах буюу алиныг хашраан гэгсгээлт үйлдсэн хэдүйч тус үл болохын цагт сүжигтэн буруу хүмүүн айлд садан нэгэн адын далдуур Чумбо Жосрайг урин залахын зөвшөөл тавихуй болой.

— Ад өгүүлрүүн:

— Шарханд тустай болбоосуу, нохойн өөхөөр өхөөлдөг л биз, дуудаад ирэгтүн гэж хэлсэн гэдэг. Ад түүнд хүмүүн тэр Жосрайг урин залсан тул, адын газарт хүрэхийг шахах лугаа Жосрайн омог хилэн босож, зарлиг ихээр би Чумбо Жосрай ирж байна болой.

— Ад тотгор нигуудын махыг идэх, цусыг уух мөний тул суу гэж зарлиглах бөгөөд түргэн заларсан тул Жосрайг дэргэд түргэн залрахад ад тэр аюух бөгөөс дэндэж, алмайрснаас эцэг, эцэг, Мила, Мила хэмээн дахин дахин өгүүлэх бөгөөд аюухын дуу олонтойг алдав.

Жосрайг дэргэдээ хүрэхүй лүгээ хүмүүн чиний байгаа газарт би чухамтай байхгүй тул миний амийг хайрла! хэмээв.

Жосрай ч ад тэрийг сүүлд үл хорлохын андгайг авах бөгөөс тавьсанд, ад тэр өөрийн эрэгзэгц хүмүүн айл нэгэнд бууснаас, бас Мила мила би зовлон хийгээд энэлгээг үл гаргана хэмээх бөгөөд сүүлд хүмүүн айл тэд нигууд юу болов хэмээхэд,

Чунбо Жосрай гарснаас аминд тултал зовлон тавив, андгайгаа алдлаа хэмээн одсон гэдэг.

Түүнээс Жосрайн эрдэм хийгээд гайхамшиг нь ихэд түгсэн тул хүмүүн хамаг бүхнээр Жосрайд Мил хэмээн нэр асаасан тул ясны алдар Мил хэмээн дуурсах болой.

Ад тэр хожим хорлол үл гаргасан тул нас эгүүдэхүйд бүхэн ам таацалдсан амой. Тэрээс Чунбо Жосрай өргөө таалсан (эхнэр авахыг) тул хөвгүүн нэг гарсан. Түүнд хөвгүүн хоёр гарсаны ууган хүүг Додонсэнгэд нэрлэж, түүнд хөвгүүн Миладоржсэнгэ хэмээх нэгэн гарсан болой. Хожим түүний үндэс дамжлагат хөвгүүн нэг, нэг буй нэгэн гарчээ. Миладоржсэнгэ тэр шоонд маш бодлоготой бөгөөд мэргэн тул мэлзлэг (мөрий) Олонг олдог бөгөөд байснаас тэр нэгэн цагт орон тэнд

хүмүүн баширтан шоонд машид мэргэн бүлэг хүмүүн олон (эцгийн хамаатан) нэгэн байсан тэд Миладоржсэнгийн хэрцлийг (хэмжээ) авахын тулд мэлзлэг өчүүхэн нэгийг тавих бөгөөд шоогоор мөрийдсэн хэрцлийг авсан болой. Тэр өдөр тэд ялахын байдлаар олсон мэт үйлдсэн тул Миладоржсэнгэ сэтгэлд болох мэт бөгөөс маргааш шоогоор дахин наадаж болно хэмээн өгүүлжээ. Мөрийг урьдаас их тавих бөгөөс шоог боосон тул амыг авахын тулд тэд гурвантаа хүртэл ялагдахын мэтийг үйлдсэний эцэст, би ч шоог авна хэмээхүйд, болно хэмээв. Мөрий их, бага хоёуланг ам таацсанаас орон, байшин, эд гурваа шооны мөрийд тавиад хойшлого үгүйд бодон бат үсгээр боосноос шоод бодлоготой тул тэд хожсон болой.

Орон, байшин, эд гурвыг тэд эцгийн хамаатан бэр бодож авсанаас Мила эцэг хөвгүүн орон суурин бүхэн лүгэ хагацсанаас оронгоосоо гарч явжуу. Ман нэрт орны Гүнтангийн Жанразай хэмээхүйд мөргөлөөр хүрсэнээс суурин засаж болой. Эцэг Додонсэнгэ оронг газарт уншлага унших, (дорма) мөндөр сахихуй, нялхсыг анагаах тэргүүтэн урин залаагаар гүйхүй тул машид даган гарсаны эрдэм хийгээд хөвгүүн Доржсэнгэ арилжаа гайхамшигтайд өвөл өмнийн Балд арилжиж, зун умрын Врогод арилжин, өчүүхэнг Ман нэрт оронд би Гүнтангийн завсарт арилжсан тул эцэг хөвгүүн эд, олон тэргүүтнээр тэр цагт орны энхрий охин нэгэн лүгэ хөвгүүн Доржсэнгэ хоёулан баясгалантын хурахуйн ханилан суув. Тэр хоёрт хөвгүүн нэгэн мэндэлсэнд Милашаравжанцанд алдар соёрхсоноос жаргалант бөгөөд буй цагт өвөг эцэг Додонсэнгэ бие завхарсаны үдлэгийг дэлгэр үйлдсэний сүүлд Миладоржсэнгэ арилжааны үүднээс эд арвижсан тул урьдаас баялаг болсон болой.

Заяын адагт орма нэрт орон, хүмүүн нэгэнд угийн тариа баясгалант гурвалжин нэгэн буй тэрийг алт хийгээд өмнө, умрын эд олноор өгөх бөгөөс арилжан аваад Ормайн гурвалжинд алдаршив. Тариа түүний захад орших айлын эрхэт хуучин байшин байсан тэрийг ч арилжин авсанаас хотын үйлийн суурийг тавих бөгөөс хотын үйлийг үйлдэхчилэнхийн байдлаас Милашаравжанцан 20 нас өнгөрөхүйлүгэ Заяын хүмүүн алдар нижгээд болсон яс Няан мөн нэгэнд Гармажан нэрт охин дүрс үзэсгэлэнт хүмүүний жам ёсонд ухаант дайсан садан алинд ч болохной тачаал, уринг гаргах нэгэн буй тэрийг гэргийд авсан бөгөөд Няангагаржанд алдаршсан амой.

Тэрээс хотын үйлийн залгамжааг учруулан, 3 давхарын дээр байшин гарын зохиолго (угаалга) зоогийн байшин өнцөгт буй 8 нуруут буй байшин Жанарзад баясгалант нэгэнг давхарыг 4 нуруут, 8 багатад алдаршсан бөгөөс амгалан, жаргалан яруу алдар луга сэлтэст бөгөөс оршсон болой.

Тэрээс хүнд Зиладодонсэнгэ эцэг хөвгүүний яруу алдарыг саданд нигууд сонссоноос Миладоржсэнгийн хамаатаны хүү Юндүнжанцан хэмээх нэрт хүү гэргий хийгээд охин дүү Чүнцабалдан луга сэлтэст бас оронгоос гарсанаас Жанарзад хүрч иржүү. Миладоржсэнгэ садан төрөлдөө их баясгалангийн мэдрэл гайхамшигтыг гаргаж бөгөөс элдэв бэлэг, элдэв шүтээнг үйлдэн орон суурин засаж, худалдаа үйлдэх ёс нигуудыг суралцуулан, худалдааны үйлээс тэд нигууд ч эд олон тэргүүтэн болжүү. Тэрээс үеэс нэгний цагт Нянцагаржан ч бие давхар луга төгөлдөр болсноос Милашаравжанцан өмнийн эд олонтойг авчрах бөгөөс умарын Дагзигийн зүгт худалдаанд орсноос өнөт байхын цагт усан эр луу жилийн намрын дунд сарын 25-нд хаан нэрт од гариг буухын өдөр ээжийгээс төрсөн тул эцгийн газарт элч илгээж болой.

Энд хуримын үйл ч тулав, над хөвгүүн нэгэн төрсөн тул хүүд нэр зүүх хийгээд нэрийн хурим үйлдэхэд өтөр ир! хэмээн захиа дуудлага элчээр эцэгт учруулах учир шалтгаан нигуудыг өгүүлсэнд, эцэг машид баясах бөгөөс, сайн болой, миний хүүгийн нэр ч ургалаа, бидний үндэс дамжлага энд хүү нэг, нэгээс буй үгүй мөний тул эдүгээ хүү төрсөн буй байгаа, тэрийг сонсоод үгэнд баясгалант нэгэн гаргаснаар миний хүүгийн нэрийг Тойвага хэмээжээ. Эдүгээ худалдаа нигууд ч дуусав., явъя хэмээснээс оронд заларчээ. Миний хүүгийн нэр «Сонсоод баясгалант» ямагтад нэрийдэв. Нэрийн хурим сайныг үйлдсэнээс энхрийлэн балчир ахуйд хожуу намайг яруу сонсголт сэтгэл баясгалант нэгэн гарсан тул хүмүүн нигууд Тойвага тэр нэрийг зүүсэн эрхэм нэгэн гарсан хэмээх болсон. Тэрээс намайг 4 нас орохын цагт ээжийгээс охин нэгэн төрсөнг Гонможид хэмээн нэр өгсөн буюу энхрий нэр нь Бидад тогтсон тул Бидагонжид гэж алдаршсан болой.

Бидэн ах дүү хоёуланд алт болоод оюу бөнжигнүүр үсэнд насгарч байсанг санана. Орондоо болбоосуу хэлэмгий ширүүн бөгөөд эрэмгий хатуу оронгын хүмүүн нөхөр нигууд луга садагнан эвсэж, бусад нигуудыг эрхэндээ боолчилж байж болохын цагт оронгын хүмүүн нигууд далдуур хочлон тэнэмэлүүд оронд тогтоод энэ амьжиргаа аль ч талаас харах лүгэ эд их байхгүй юм байхгүй, гадаад тал байшин, тариалан, дотоод талдаа өлөг, эр, эмийн чимэг алинд харах болохной ч дутуугүй байгаа хэмээхүй бүхэн ам түрхэхсэний агаараас Миладоржсэнгэ бие өөд болсон бөгөөс таалал төгссөний арга нигууд дэлгэр бүтээх мөн гэж зарлиглав. Бие мэндэлсний зохиол бөгөөд анхных болой.

Бүлэг II.

Бас Райчүн айлтгаваас;

— Лам тан

— Анх, эцэг лүгэ хагацсан тул чилэн алжаал олныг таалалдаа анхааран авсан гэж хэмээн зарлигладаг ямар мэт хэмээхүй мөн бол гэж айлтгасанд, тэрээс би долоон нас төдий одохын цагт, Милшаравжанцан тэр чилээн суурь хатуу өвөр нэг эзлэгдсэнээс, эмч хийгээд тарничин нугууд чу үл эдгэрэхүйг хүртэл ишийг үзүүлэхүй бөгөөд орхив. Садан төрөл барилдлагаатан бүхэн ч үл амьжирахыг хүртэл мэдэв.

Тэр өөрөө ч үл амьдрахаа лавтай шийдсэнээс, авга ах, авга эгч тэргүүлэн садан төрөл, ойр холын нөхөр, баясгалант оронгийн хүмүүн айл сайрхаг нөхөр бүхнээ цуглуулсан болой.

Эх хөвгүүн эд лүгэ сэлтэстийн захиан үгийг үйлдсэнээс, эцэст эцгийн орныг хөвгүүн барихуйд оруулахын гэрээс бичгийг дэлгэр үйлдсэн амой. Бүхэнд сонсгон дуурсгаад, утгыг үгэнд товч хураан эдүгэ би өвчин энэбээр үл тавигдах байна бөгөөд, тэрээс миний хөвгүүн энэ ч эдүгэ өчүүхэн байгаа тул авга ах хийгээд авга эгч тэргүүлэн үйлдэгч, садан нөхөр бүхэнд захиан үг үйлдэх учиртайд:

Миний хүүд болвоос эд, сарлаг, морь, хонь гурав, Оромдүйсүм тэргүүлэн үйлдэх тариалан, батганын хушуу үл багтахуйц, байшингийн доор мал, үхэр, ямаа, илжиг гурав, байшингийн дээр өлөг, алт, мөнгө, зэс, төмөр, оюу хийгээд хив торго үрийн сан тэргүүтэн болой. Товчилбоос, хүмүүний эд бусдад шулагдахын хэрэггүй байгаа тул энэ нугуудын дээрээс хувь нэгийг эдүгээ миний хойтод зориул. Тэрээс үлэгсэн нугуудыг та нар энд цугларагсан бүхэн миний хөвгүүн энэ бэр оронг барихуй хүртэл хадгална болой. Ялгаамжтайд авга ах хийгээд авга эгч хоёрт захиана болой. Хөвгүүн орныг барихуй хийгээд Сүйт

лүгэ сайрхан садагнан эвсүүлж байгаа тул охин өөрөө бэлэг угтуулгын эд нугуудыг ч үлдээлгүй өгөх, эцгийн орныг хөвгүүн еэр барихад оруулагтун.

Тэрний завсарт миний хөвгүүн, эх охин гурав жаргах зовохыг та авга ах ба авга эгч эрхэм үйлдэгч ураг садан бүхэн мэднэ болой.

Зовлонд бүү оруулагтун!

«Би үхэвч үхээрийн нүхнээс харна» болой хэмээн зарлигласнаас таалал төгсжүү.

Тэрээс эцгийн оршуулгын сүүлийг үйлдсэн тул, тэр үлдсэн эд нигуудыг бүхэн ам булаалдахад сүйтийн эцэг өгүүлрүүн:

— Нянцайгаржанд өөрт нь чандлан хадгалуулаад бид нар хэрэгтэй бүхнийг хажуугаас юу туслалцах хэмээхэд:

— Авга ах, авга эгч хоёр өгүүлрүүн:

«Төрлийн ойр гэвэл бид хоёр л ойр, тэд эх хөвгүүн гурвыг зовлонд үл оруулна. Эд хогшил нигуудыг гэрээсчилэнх бид хадгалж үйлдэнэ хэмээв.

Миний нагац, сүйтийн эцгийн үгийн учир түүхийг өгүүлэхүйг үл сонсон, эрийн эд нигуудыг авга ах, аваад эмийн эд нигуудыг авга эгч аваад, бусад нигуудыг хамар халз хувааж авсан амой.

Та эх хөвгүүн нигуудыг асрамжлан үйлдэнэ гэж хэлснээс бид эх хөвгүүн гуравт эд эрхлэхийн учир үл гарсан болой. Зун тариалангийн үйл үйлдэхүй цагт авга ахын боол, өвөл унгасны үйл үйлдэх үед авга эгчийн боол, хоол нохойн хоол, үйл илжигний үйлт, уранхай хувцас эгмэн тасархай, олсон бүсийг зангидан бүслэснээс, үйл чөлөөгүй үйлдэх хэрэгтэй болсон тул үе мөч нь осгооруутан хагартаж одов. Хоол, хувцас муугийн эрхээр, царай нь хонхийн цайвартаж, туранхайран эцэнхийрч үс нь анхандаа алт оюу үс насгарсгаар байдаг байсан бол хожим цайвартаж бөөс хуурс үсэнд нь ширэлдэн гялтганаж байх болсон тул, үзсэн хийгээд сонссон уяхан сэтгэлт бүхэн нулимс алдах хий гээд, авга ах, авга эгчийг далдуур хочлон муучлах нь цээргүй болсон. Бид эх хөвгүүнд зовлон ямагт тавьсан тул, тэрээр авга эгчийг Чүнбалдан биш «өлөгчин бар шулам» байна хэмээсэн тул авга эгчийг «өлөгчин бар шулам»-д нэр тогтов.

Тэр цагт ертөнцийн үг үлгэрт «Эзэн бус эзэнд горилж, эзэн нь үүдэн нохойд гарна» хэмээхүй чинь бид эх хөвгүүнд гарлаа. Урьд Милшаравжанцанг оршиж байхын цагт, хүмүүн сайрхаг бусад бүхэн бидний нүүрийн мөшгөөлтийн сайн мууг харж байсан мөн бөгөөд хожим эд буйгаа алдахын ёсонд одсоноос, авга ах хийгээд авга эгчийн царайн сайн мууг харах боллоо.

Ээжийг ч хүмүүн нугууд далдуураа «эр нь ухаантай бол эм нь цэцэн, унгас нь зөөлөн бол цэмбэ нь сайн» гэдэг тэр үнэнд байна болой. Хүмүүн боломжоо үгүй болохын цагт үлгэр энэ лүгэ адил.

Анх Нянцайгаржан эр сайнаар өөд татагдахын цагт, эмийн оюун ухаан их цэцэн, гарын өгөөж сайтай хэмээхүй байдаг билээ. Тэр эдүгээ зовлон нижгээд гарсанд үг нижгээд сайн үлгэр энэ өөрөөс дорой бүхэн араас муучлах болсон. Над сүйтийн эцэг, эх дээл, гутал өгснөөс хүмүүн эд эс одсоноос эд мөнх бус өвсний үзүүрийн гялбаа мэт мөн тул эд гэж бодох хэрэггүй. Анх, эцэг хүмүүн нугууд ч эд хожмоо л гарсан мөн.

Та нарт ч эдтэй болох чиг цаг байгаа хэмээснээс санааг засаж, дахин дахин тавьсан, тэр би арван нас хүрэхийг шахамдахын цагт, эжид эцгийн инжинд өгсөн тариалан Бриви данчүн хэмээхүй нэр яргуу бус болохной ч намар турш арвин ургадаг байсан. Тэрийг нагац аж амьжиргааг үйлдэх болсноос арвижин дэлгэрэхүйд хэр адуугуулж үйл-

дээд, далд хурааж байгаад машинд элбэг болсонд мах олныг наймаалаад, цагаан будаа элбэг, гурил үйлдэж, хар тариа элбэг архи нэрэх тул Нянцайгаржан эх хөвгүүн эд хуримтлуулж үйлдэхүй байгаа хэмээхүй цуу гарав.

Тэрээс бид бэр өөрийн байшин дөрвөн баганат, найман нурууг түүндээ дэвсгэр олныг зээлсэнээс тавьсан бөгөөд, авга ах хийгээд авга эгч тэргүүлж үйлдэгч садан, ойрын нөхөд, нөхөр баясгалант оронгийн хүмүүн айл сайрхаг нугууд хийгээд, ялгаамжтай эцэг Милшаравжанцан биеийн оршуулгын дээр гэрээс бичиг, уг учир түүхт нугуудыг цуглуулахуй бөгөөс авга ах хийгээд авга эгчид бүхэл мах тавиад, бусдад хөл хүрэхэд нь хөл тавьж, мөч хүрэхэд нь мөч тавив.

Нянцайгаржан цагаан шаазанд архи, хадаг луга сэлтэстийн хурим сайнаар татсанаас эжий суудлаас босох бөгөөс өө! сайн болой.

— Хөвгүүн төрөхүйд нэр, архи өргөхүйд үг хэлэхүй байдаг тул.

— Би ч хэдэн үгийг хэлэх мөний тул, эцэг Милшаравжанцан таалал төгсөхүйдөө гэрээс бичгийг зарлигласан учир байгаа хүмүүн өвгөд авга ах, авга эгч тэргүүлэн зохиогч суугаа зочин нугуудын сонорт сонсгон айлтгая, нагац эцгийн гэрээс бичгийг уншсаны эцэст ээжий үсэг түүний утгын зарлигийг хэл лугаа сэлтэст энд байгаа өвгөд бүхний таалалд тодорхой тул дэлгэр айлтгахын хэрэггүй байгаа, утгыг хуулилуулахад (хураахад) хэзээний тустай авга ах хийгээд авга эгч хоёр бидэн эх хөвгүүн өөд татахыг үнэхээр зохиосон, таалалдаа авсан. Эдүгэ миний хөвгүүн хийгээд сүйт хоёул гэрийг барих гэж байгаа тул, бидэн өөрийн эд захиасан нугуудыг шаардахуй хийгээд сүйтийг ч бэлэг угтуулахаас эцгийн гэрээсээр эцгийн оронг хөвгүүн барихуйд оруулахуйг айлтгая хэмээв. Авга ах хийгээд авга эгч хоёр юунд ч үл таалалдахуй болохной ч хоолонд таацалдах хийгээд та нарт хөвгүүн нэг л байгаа хийгээд авга ах, авга эгч бидэнд хөвгүүн олон байгааг харж байгаа биз, авга эгч хийгээд авга ах эвсэлдсэнээс та нарын эд байгаа буюу тэр чинь юу байгаа мөн, анхан Милшаравжанцан тэр өөрөө бие сайн байхдаа байшин, тариалан, алт, оюу, хайнаг, морь, сарлаг, хонь нугуудыг биднээс зээлэн авсан, тэр өөрөө үхэхийг шахамдахдаа эзэнд буцааж тушаасан мөн.

Та нар өөрийн эрхлэх эд алт нэг цэн буюу, тариа хормой дүүрэх буюу тос гүзээ нэг бусдад дээлийн торго утасны ширхэг нэг, адуу мал газар тамгалах нэгийг ч нүдээр эс үзсэнд эдүгэ энэ адил хэмээнэ болой. Чиний гэрээсийн бичгийг хэн бичсэн юм. Зовлонт эх хөвгүүнийг хооллож, өлсгөж үхүүлээгүй асрамжилсан бид мөн.

Ер хүмүүн муу эрд эрхийг дурьдах болвоосуу, усыг хувингаар юүлэх хэмээхүй тэр, энэ адил хэмээхүй мөн байна. Хамраа шухирч хуруу нанчиж, «хормой шууж, хөлөө дэвсэлснээс тэгвээс байшин ч бидний эрхшээлийн тул хүүр мэт эх хөвгүүн сөөргөн гар хэмээхүй бөгөөд ээжийг төмрөөр ташуурдан тэнд ах бид хоёрыг ханцуйныхаа нударгаар нударгалав.

Тэр цагт ээжий эцэг Милшаравжанцан бид эх хөвгүүний үйлийг тухайд болгоох хийгээд үхээрийн нүхнээс харна болой гэж зарлигласан тэр, эдүгэ болгоох цаг буусан байна болой, хэмээгээд уйлах бөгөөд эхэр татсанаас уруу өөдгүй хөлбөрөн хөлбөрөхүй бөгөөд байсан. Бид хоёр уйлахаас өөр юмгүй, ээжийг нагац авга ах ба авга эгчид хөвгүүн олон байгаа тул эсэргүүцэн үл чадна, бусад оронгийн хүмүүн та нарт сайн нигууд энд эх хөвгүүнийг өрөвдөхүй байнаа хэмээн нулимс алдан алдан байв. Бусад нугууд санаагаа уртаар алдаж байсан гэдэг.

Авга ах хийгээд авга эгч бидэнд эд хэрэгтэй хэмээн, эд та нарт л байгаа байна. Оронгийн хүмүүн айл, сайрхаг бүхэнд мах архийг хайр найргүй заран хурим үйлдэхийн учир юу байна. Чиний эн эд бидэнд үгүй, байсан ч үл өгнө, та нар олон бол цэрэг тат, цөөн бол хараал зүхэл хэлүүл хэмээх бөгөөс гарч одов.

Ээжий тэрээс ч уйлахаас өөргүй байхуйд нагац хийгээд сүйт хүмүүн тэргүүтэн тэд өөрт сайн хүмүүн бүхэн ээжийн сэтгэлийг сэргээхийн тулд сууснаас архины үлдвэрийг уух бөгөөд ээжид одоо бүү уйл уйлаад тус болох биш. Өнөөдөр энд хуримд цугларсан бүхэн ч юу эд гуйх инжгээдийг тэд нар ч юу хэрэгтэйг өгнө гэв.

Авга ах, авга эгч хоёр ч юу сайн нижгээдийг ч өгнө байх хэмээхэд;

— Нагац өгүүлрүүн:

— Энэ хөвгүүнд эрдэм нэгийг сурахаар явуул! Та нар өөрсдөө эх охин миний газарт суун, тариалангийн аж зуулгаар юу тустай үйлийг үйлдэхээс өөр зохистой юмгүй. Алинаас ч авга ах, авга эгчийн нүүрийг халамцуулахгүй нэгийг үйлдэх хэрэгтэй хэмээхэд:

— Ээжий өгүүлрүүн:

— Өөрийн эдийг эрхшээх учиргүй болсон хэдүй ч гуйж үйлдсэн эдээр би бэр хөвгүүнээ тэжээх үгүй болой. Авга ах хийгээд авга эгч бидний өөрийн эд хувь нэгийг тушааж өгснийг авахгүй. Хөвгүүн ч эрдэм нэгийг сурахаар яавч явуулна.

Бид, эх охин, авга ах хийгээд авга эгчээр халамж үзүүлэлгүйн сүүлд хэнгэрэгний дуугаар гүйхүй хийгээд уутаа багширсанд гуйж үйлдэхнээ ч тэр хоёрын нүүрийг царайчлахгүй мөн.

Тариалангийн аж зуулгыг ч энэ хоёроос үйлдэхгүй хэмээв. Заяын митон гадхай хэмээхүй газарт хуучин таринин багш Лужадхан урин залагддаг нэгэн байсан түүнд намайг уншлага сургахаар явуулав.

Тэр цагт садан ч эд гуйснаар ахар шаахар нижгээдийг өгч байсан. Ялгаамжтай сүйтийн эцэг, эх хоол хүнс галын модноос дээшийг өгсөнөөс намайг уншлага суралцах газарт сүйт охин ч миний сэтгэлийг сэргээж дахин дахин явуулах болсон. Нагац, ээжий хийгээд дүү хүний үйл үйлдэж цагийн хоолыг ч чадаж байв. Ээжийг гуйлганд одуулалгүй, нагац хүний үйл өдрийг өдөрт дээс томохыг өдөрт нь томох бөгөөд, бидэн ээжий охин дүү энд юу тустай хийгээд эд юуг цуглуулж үйлдсэн тул, охин дүү юу чадахаар хүний боол болох хийгээд, хэнгэрэгийн дуунаар гуйж, утаа уугиснаар үйлдсэнээс хоол хувцас юухан олж үйлдэх болохной ч хоол муу, хувцас элэнхий, сэтгэл гонсойсноос жаргалан ямагтыг амсаагүй гэж зарлиглав.

Тэр цагт номыг сонсох болоход хэмжээлшгүй таалал уйдаг хийгээд магад гансрахын үүднээс нулимс алдах бөгөөс түргэн нэгэн бүхэн дув дуугүй байсан гэдэг.

Зовлонгийн үнэнийг туйлд нь хүргэсэн анхааран авсаны зохиол бөгөөс хоёрдугаар болой.

(үргэлжлэл нь дараагийн дугаарт)

Д. Цэдэв